



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/813/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a>
Улаанбаатар хот	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр
2025 он	Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:undarmaam@audit.gov.mn">undarmaam@audit.gov.mn</a>
	Аудитор: Г.Тэмүүжин Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:temuujing@audit.gov.mn">temuujing@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Улс, орон нутгийн төсөвт 2024 онд Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс нь 224,611,208.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 230,492,593.1 мянган төгрөг буюу 102.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Аудит хийсэн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>74,281,575.76</b>	<b>70,988,913.66</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>726,297.64</b>	<b>726,297.64</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	726,297.64	726,297.64
<b>3351</b>	<b>Байгууллагаас авах авлага</b>	726,297.64	726,297.64
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>73,555,278.12</b>	<b>70,262,616.02</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>73,555,278.12</b>	<b>70,262,616.02</b>
35410	Бичиг хэргийн материал	6,977,629.94	3,398,327.84
35420	Аж ахуйн материал	2,685,260.00	1,243,580.00
35440	Түлш, шатах тослох материал	755,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	63,137,388.18	65,620,708.18
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,010,624,431.26</b>	<b>1,121,784,969.76</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,010,624,431.26</b>	<b>1,121,784,969.76</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,006,172,568.25</b>	<b>1,117,572,847.73</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	957,952,451.44	957,952,451.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-79,353,521.44	-106,936,913.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,999,000.00	41,999,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,620,110.52	-33,378,879.94
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	338,957,846.63	494,243,346.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-238,283,040.76	-316,338,023.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,562,299.52	132,104,679.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,042,356.62	-52,072,811.95
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,451,863.01</b>	<b>4,212,122.03</b>
39301	Програм хангамж	957,000.00	957,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-480,136.99	-719,877.97
39303	Бусад биет бус хөрөнгө	3,975,000.00	3,975,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,084,906,007.02</b>	<b>1,192,773,883.42</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,084,906,007.02</b>	<b>1,192,773,883.42</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,084,906,007.02</b>	<b>1,192,773,883.42</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	655,748,149.40	655,748,149.40
51101	Өмч: - төрийн	655,748,149.40	655,748,149.40
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>119,187,186.04</b>	<b>227,055,062.44</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-260,534,614.86	119,187,186.04
51220	Тайлант үеийн үр дүн	379,721,800.90	107,867,876.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	309,970,671.58	309,970,671.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,084,906,007.02</b>	<b>1,192,773,883.42</b>

Аудит хийсэн 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,219,409,913.36</b>	<b>3,583,161,656.49</b>

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>445,657,649.36</b>	<b>242,092,656.49</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>445,657,649.36</b>	<b>242,092,656.49</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	445,657,649.36	242,092,656.49
120010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	442,620,652.36	240,941,660.49
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	3,036,997.00	1,150,996.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,773,752,264.00</b>	<b>3,341,069,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,635,658,100.00</b>	<b>3,037,045,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,635,658,100.00	3,037,045,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>138,094,164.00</b>	<b>304,023,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,094,164.00	304,023,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,838,622,275.18</b>	<b>3,475,293,780.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,838,622,275.18</b>	<b>3,475,293,780.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,496,306,229.35</b>	<b>3,337,920,559.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,999,871,783.70</b>	<b>2,588,473,444.38</b>
210101	Үндсэн цалин	1,004,923,052.35	1,327,473,833.10
210102	Нэмэгдэл	257,140,047.04	420,847,801.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	132,263,061.74	176,173,582.21
210104	Урамшуулал	605,545,622.57	663,978,227.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>247,501,206.48</b>	<b>326,193,717.89</b>
210201	Тэтгэврийн даатгал	170,742,244.70	225,833,157.52
210202	Тэтгэмжийн даатгал	20,156,072.90	25,777,023.96
210203	ҮОМШ өвчний даатгал	15,533,058.23	12,851,092.85
210204	Ажилгүйдлын даатгал	3,600,082.91	12,346,468.66
210205	Эрүүл мэндийн даатгал	37,469,747.74	49,385,974.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,320,529.07</b>	<b>19,186,024.80</b>
210301	Гэрэл цахилгаан	5,853,230.49	6,842,472.55
210302	Түлш, халаалт	5,795,425.16	6,595,867.25
210303	Цэвэр, бохир ус	4,671,873.42	5,747,685.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>63,892,452.04</b>	<b>52,179,034.85</b>
210401	Бичиг хэрэг	11,873,631.99	23,090,188.10
210402	Тээвэр, шатахуун	27,834,960.00	14,055,000.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	18,306,513.09	11,159,866.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,000.00	744,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,133,346.96	3,129,980.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,327,761.51</b>	<b>1,883,200.00</b>
210604	Урсгал засвар	4,327,761.51	1,883,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,035,086.00</b>	<b>190,826,886.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,312,800.00	177,497,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,410.00	376,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	233,176.00	99,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	12,796,400.00
210807	Газрын төлбөр	35,700.00	35,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>124,357,410.55</b>	<b>159,178,251.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,943,000.00	2,123,130.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	5,833,200.00	17,275,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	82,581,210.55	139,780,121.99
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>342,316,045.83</b>	<b>137,373,220.18</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>37,781,940.00</b>	<b>106,752,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,400,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,381,940.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	106,752,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>304,534,105.83</b>	<b>30,621,220.18</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,534,105.83	30,621,220.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>380,787,638.18</b>	<b>107,867,876.40</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,065,837.28</b>	<b>0.00</b>
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	1,065,837.28	0.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-1,065,837.28</b>	<b>0.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>379,721,800.90</b>	<b>107,867,876.40</b>

### Аудит хийсэн 2024 оны мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	2,773,752,264.00	3,341,069,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	2,773,752,264.00	3,341,069,000.00
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,635,658,100.00	3,037,045,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,635,658,100.00	3,037,045,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	138,094,164.00	304,023,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	138,094,164.00	304,023,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	2,767,152,264.00	3,331,070,000.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,767,152,264.00	3,331,070,000.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,424,836,218.17	3,193,696,779.82
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,999,871,783.70	2,588,473,444.38
210101	Үндсэн цалин	1,004,923,052.35	1,327,473,833.10
210102	Нэмэгдэл	257,140,047.04	420,847,801.86
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	132,263,061.74	176,173,582.21
210104	Урамшуулал	605,545,622.57	663,978,227.21
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	247,501,206.48	326,193,717.89
210201	Тэтгэврийн даатгал	170,742,244.70	225,833,157.52
210202	Тэтгэмжийн даатгал	20,156,072.90	25,777,023.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,533,058.23	12,851,092.85
210204	Ажилгүйдлийн даатгал	3,600,082.91	12,346,468.66
210205	Эрүүл мэндийн даатгал	37,469,747.74	49,385,974.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,320,529.07	19,186,024.80
210301	Гэрэл, цахилгаан	5,853,230.49	6,842,472.55
210302	Түлш, халаалт	5,795,425.16	6,595,867.25
210303	Цэвэр, бохир ус	4,671,873.42	5,747,685.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	57,972,616.12	48,313,506.75
210401	Бичиг хэрэг	9,620,500.00	20,704,890.00
210402	Тээвэр, шатахуун	27,804,960.00	13,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,103,156.12	10,682,866.75

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,000.00	744,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,700,000.00	2,881,750.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,829,996.80</b>	<b>3,383,200.00</b>
210604	Урсгал засвар	3,829,996.80	3,383,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,560,086.00</b>	<b>190,826,886.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,837,800.00	177,497,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	431,410.00	376,510.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	233,176.00	99,276.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	12,796,400.00
210807	Газрын төлбөр	35,700.00	35,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>39,780,000.00</b>	<b>17,320,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,280,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,500,000.00	17,320,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>342,316,045.83</b>	<b>137,373,220.18</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>37,781,940.00</b>	<b>106,752,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,400,000.00	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,381,940.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	106,752,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>304,534,105.83</b>	<b>30,621,220.18</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	304,534,105.83	30,621,220.18
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,600,000.00</b>	<b>9,999,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,600,000.00</b>	<b>9,999,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,600,000.00</b>	<b>9,999,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,600,000.00</b>	<b>9,999,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	6,600,000.00	9,999,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-6,600,000.00</b>	<b>-9,999,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## Аудит хийсэн 2024 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	-260,534,614.86	0.00	705,184,206.12
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	-260,534,614.86	0.00	705,184,206.12
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	379,721,800.90	0.00	379,721,800.90
C08	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	119,187,186.04	0.00	1,084,906,007.02
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	119,187,186.04	0.00	1,084,906,007.02
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	119,187,186.04	0.00	1,084,906,007.02
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	107,867,876.40	0.00	107,867,876.40
D09	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	655,748,149.40	309,970,671.58	227,055,062.44	0.00	1,192,773,883.42

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,037,045,600.00</b>	<b>3,006,664,379.82</b>	<b>30,381,220.18</b>	99.0%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,037,045,600.00</b>	<b>3,006,664,379.82</b>	<b>30,381,220.18</b>	99.0%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,034,405,600.00</b>	3,004,024,379.82	<b>30,381,220.18</b>	99.0%
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,611,601,100.00</b>	<b>2,588,473,444.38</b>	<b>23,127,655.62</b>	99.1%
210101	Үндсэн цалин	1,243,663,700.00	1,327,473,833.10	-	106.7%
210102	Нэмэгдэл	430,186,300.00	420,847,801.86	<b>9,338,498.14</b>	97.8%
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	177,760,000.00	176,173,582.21	<b>1,586,417.79</b>	99.1%
210104	Урамшуулал	759,991,100.00	663,978,227.21	<b>96,012,872.79</b>	87.4%
210105	Гэрээт ажлын хөлс		0.00	<b>0.00</b>	

2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>326,450,200.00</b>	<b>326,193,717.89</b>	<b>256,482.11</b>	99.9%
210201	Тэтгэврийн даатгал	224,626,100.00	225,833,157.52	<b>-1,207,057.52</b>	100.5%
210202	Тэтгэмжийн даатгал	25,456,000.00	25,777,023.96	<b>-321,023.96</b>	101.3%
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,728,100.00	12,851,092.85	<b>-122,992.85</b>	101.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	12,728,100.00	12,346,468.66	<b>381,631.34</b>	97.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	50,911,900.00	49,385,974.90	<b>1,525,925.10</b>	97.0%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,752,200.00</b>	<b>19,186,024.80</b>	<b>566,175.20</b>	97.1%
210301	Гэрэл, цахилгаан	7,170,800.00	6,842,472.55	<b>328,327.45</b>	95.4%
210302	Түлш, халаалт	6,925,800.00	6,595,867.25	<b>329,932.75</b>	95.2%
210303	Цэвэр, бохир ус	5,655,600.00	5,747,685.00	<b>-92,085.00</b>	101.6%
210304	Байрны түрээс	0.00	0.00	<b>0.00</b>	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,744,000.00</b>	<b>19,114,506.75</b>	<b>629,493.25</b>	96.8%
210401	Бичиг хэрэг	5,600,000.00	5,589,890.00	<b>10,110.00</b>	99.8%
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00	<b>0.00</b>	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,800,000.00	9,182,866.75	<b>617,133.25</b>	93.7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	744,000.00	744,000.00	<b>0.00</b>	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,000.00	2,397,750.00	<b>2,250.00</b>	99.9%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,600,000.00</b>	<b>3,383,200.00</b>	<b>216,800.00</b>	94.0%
210604	Урсгал засвар	3,600,000.00	3,383,200.00	<b>216,800.00</b>	94.0%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>45,758,100.00</b>	<b>42,233,486.00</b>	<b>3,524,614.00</b>	92.3%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,200,000.00	40,200,000.00	<b>3,000,000.00</b>	93.1%
210803	Даатгалын үйлчилгээ	439,100.00	376,510.00	<b>62,590.00</b>	85.7%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,300.00	99,276.00	<b>24.00</b>	100.0%

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	<b>0.00</b>	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,962,000.00	1,500,000.00	<b>462,000.00</b>	76.5%
210807	Газрын төлбөр	35,700.00	35,700.00	<b>0.00</b>	100.0%
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,500,000.00</b>	<b>7,420,000.00</b>	<b>80,000.00</b>	98.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	7,500,000.00	7,420,000.00	<b>80,000.00</b>	98.9%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,640,000.00</b>	<b>660,000.00</b>	<b>1,980,000.00</b>	25.0%
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,640,000.00</b>	<b>660,000.00</b>	<b>1,980,000.00</b>	25.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,640,000.00	660,000.00	<b>1,980,000.00</b>	25.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,037,045,600.00</b>	<b>3,006,664,379.82</b>	<b>30,381,220.18</b>	99.0%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,037,045,600.00</b>	<b>3,006,664,379.82</b>	<b>30,381,220.18</b>	99.0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,037,045,600.00	3,006,664,379.82	<b>30,381,220.18</b>	99.0%
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	100.0%
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	<b>0.00</b>	100.0%
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>82.00</b>	<b>74.00</b>	<b>8.00</b>	90.2%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	<b>0.00</b>	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	76.00	76.00	<b>0.00</b>	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	<b>0.00</b>	100.0%
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	0.00	0.00	<b>0.00</b>	
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>82.00</b>	<b>74.00</b>	<b>8.00</b>	90.2%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	77.00	71.00	<b>6.00</b>	92.2%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	3.00	<b>2.00</b>	60.0%

## Аудит хийсэн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>304,023,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>304,023,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>197,691,400.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>29,199,000.00</b>
210401	Бичиг хэрэг	53,730,473.71	15,115,000.00
210402	Тээвэр, шатахуун	53,730,473.71	12,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	53,730,473.71	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,730,473.71	484,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>9,999,000.00</b>
<b>210601</b>	<b>Багаж, техник, хэрэгсэл</b>	<b>53,730,473.71</b>	<b>9,999,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>148,593,400.00</b>
<b>210801</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>53,730,473.71</b>	<b>137,297,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	53,730,473.71	11,296,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>9,900,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,730,473.71	9,900,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>106,332,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>106,092,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,730,473.71	106,092,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>240,000.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	53,730,473.71	240,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>304,023,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>304,023,400.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,730,473.71	304,023,400.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 3,094,732.4 мянган төгрөгийн 3 алдаа<sup>2</sup> илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

1. Үнэ төлбөргүй хүлээн авсан 56,535.8 мянган төгрөгийн бараа материалын орлого, зарлагыг үр дүнгийн тайланд тусгаагүй.
2. Үнэ төлбөргүй хүлээн авсан 1,151.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үр дүнгийн тайланд зөрүүтэй илэрхийлсэн.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 3,037,045.6 мянган төгрөгийн улсын төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр болон гүйцэтгэлийг дутуу тайлагнасан.

Аудитаар нийт 48,901.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 30,675.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 17,500.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1. Эрт илрүүлэг, Эрүүл монгол хөтөлбөртэй давхардуулж үйл ажиллагаа тодорхой бус компанитай гэрээ байгуулан ажилчдыг шүдний эрүүл мэндийн үзлэгт хамруулан 19,800.0 мянган төгрөгийн төсвийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 19,800.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Дүүргийн Засаг даргаас олгосон дэмжлэгээс ажилтнуудад нэг удаагийн дэмжлэг олгоходоо 10,875.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын суутган тооцоогүй байна.

Шийдвэрлэсэн нь : Төсөвт төвлөрүүлэх ХХОАТ-ыг төсөвт төвлөрүүлээгүй 10,875.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Үйл ажиллагааны чиглэл өөр байгууллагатай сургалтын ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ байгуулж 17,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь : Улсын бүртгэлийн гэрчилгээнд зөвшөөрсөн үйл ажиллагааны чиглэлтэй хуулийн этгээдээс үйлчилгээ аваагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар нийт 1,572,851.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 19,400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1,553,451.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт1:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 4,728,360.3 мянган төгрөгийн 46 мэдээллийг ил тод байршуулахаас цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 1,407,417.1 мянган төгрөгийн 6 гүйлгээг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, иж бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт2:** Төсвийн хөрөнгөөр 19,400.0 мянган төгрөгөөр спортын тэмцээн уралдаан зохион байгуулж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг зогсоож давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

**Илрүүлэлт3:** Тайлант онд 15,329.6 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд хүсэлт илгээж, худалдан авалт хийгээгүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, материал, хөрөнгийн саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн бараа, үйлчилгээг худалдан авч байх зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт4:** Дүүргийн Засаг даргаас олгосон 108,754.0 мянган төгрөгийн дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч ажилтнуудад нэг удаагийн дэмжлэг олгосон.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж батлагдсан төсвийн хүрээнд, холбогдох журмын дагуу урамшуулал олгох зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт 5** : Сургалт сурталчилгаатай холбоотой 21,950.0 мянган төгрөгийн зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалт сурталчилагаатай холбоотой зардлын үр дүнг үнэлж хэвших зөвлөмж өгөв.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр /

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СХД-ийн Татварын хэлтэс	1	56.5	1	56.5			1	56.5				
	1	1.1			1	1.1	1	1.1				
	1	3,037.0	1	3,037.0			1	3,037.0				
Дүн	3	3,094.7	2	3,093.5	1	1.1	3	3,094.7				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ сая төгрөгөөр /

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
СХД-ийн Татварын хэлтэс	1	17.5			1	17.5							
	1	19.8	1	19.8									
	1	10.8	1	10.8									
Дүн	3	48.1	2	30.6	1	17.5							

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/ сая төгрөгөөр /

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
СХД-ийн Татварын хэлтэс	1	1,407.4						1	1,407.4	
Дүн	1	1,407.4						2	923.8	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
СХД-ийн Татварын хэлтэс	1	15.3						1	15.3	
	1	108.7						1	108.7	
	1	19.4			1	19.4				
	1	21.9						1	21.9	
Дүн	4	165.4					1	19.4	3	146.0
Нийт дүн	5	1,572.8					1	19.4	3	146.0

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

/сая төгрөгөөр /

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			